



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№145 /359/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.08.17

Цаг үе, үйл явдал

ЦОГЦОЛБОР ШАЛГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн зорилго, зорилтын хэрэгжилт, зохион байгуулагдсан цэргийн сургалт бэлтгэлийн үр дүнг тооцож, Зэвсэгт хүчний Төргийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, салбарын бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшинг үнэлж, үүрэг гүйцэтгэх бодит чадавхыг тогтоох зорилгоор сургуулийн жилийн төгсөлтийн шалгалтыг зохион байгуулж байна.

Энэ жилийн хувьд Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн төгсгөлийн ЗХЖШ-ын цогцолбор

шалгалтад 2022 оны 08 дүгээр сарын 15-22-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 167, 325 дугаар ангиудад 2022 оны 08 дугаар сарын 22-оос 09 дүгээр сарын 02-ны өдрийг дуустал Зэвсэгт хүчний 032, 016, 013, 310 дугаар ангиуд хамрагдаж, Агаарын цэргийн командлалын цогцолбор шалгалтад Зэвсэгт хүчний 337 дугаар анги, Тусгай хүчний цэргийн командлалын шалгалтад Зэвсэгт хүчний 331, 350 дугаар ангиуд тус тус хамрагдах бөгөөд шалгалтад хамрагдаагүй бусад нэгтгэл, ангиуд захирагчийн нэрэмжит шалгалтыг 2022 оны 09 дүгээр сарын 05-наас 15-ны

өдрүүдэд зохион байгуулагдана.

ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан цогцолбор шалгалтын комиссын бүрэлдэхүүн энэ сарын 15-наас Зэвсэгт хүчний 167 дугаар ангиас сургуулийн жилийн төгсөлтийн шалгалтыг эхлүүлэн, ажиллаж байна.

ЗХЖШ-ын цогцолбор шалгалтаар нэгтгэл, ангиудын үндсэн болон хуулиар хүлээсэн бусад үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшинг таван цагийн орон тооны хүч хэрэгслээр өгөгдсөн цагийн байдалд ажиллах дадлага, жигдрэлтээр болон байлдааны

болон бүх талын хангалтын бэлэн байдлын үзүүлэлтээр шалган үнэлж байна. Түүнээс гадна нэгтгэл, анги, салбаруудын өвөлжилтийн бэлтгэл, сургуулийн жилийн цэргийн албаны зохион байгуулалт, сахилгын байдал, цэргийн сургалт бэлтгэлийн түвшин, бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн хангалтын болон мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт, хамгаалалтын байдлыг сүүлийн 4 жилийн хугацаатай харьцуулан үнэлж дүгнэх юм.

Ахмад Б.ЖАВХЛАНТӨГС

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌧️ 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.183.53	3.202.0
EUR 🇪🇺	3.283.0	3.300.0
CNY 🇨🇳	470.50	480.00
RUB 🇷🇺	42.40	57.00
JPY 🇯🇵	23.40	24.37
KRW 🇰🇷	2.32	2.49

ЗУРХАЙ



2022.08.17 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 15

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР БАР ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал арвидна

Наран ургах, шингэх:

05.42-20.13

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал: Ус

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

ОЙРЫН ЗАЙН ХОЛИМОГ БУУХИАН ТЭМЦЭЭН ОХУ-ЫН БАГААР ЭХЭЛЛЭЭ

"Аравт-2022" олон улсын морин цэргийн уралдааны ойрын зайн холимог буухиа 8 дугаар сарын 17-ны энэ өдөр ОХУ-ын баг тамирчдаар эхэллээ.

Ойрын зайн холимог буухиагаар сонсогч Ш.К.Леонидович захирагчтай тасгийн залуус явган 3.1 км, морьтой 4.1 км замыг туулж, маршрутын дагуу байрлах цэгт гранат шидэх, саадын зурвас туулах, буудлагын дасгал гүйцэтгэх, тактикийн ажиллагаа, морины давхилт дунд гранат шидэх зэрэг даалгавруудыг амжилттай гүйцэтгээд барианд орсон юм.

УЗБЕКИСТАНЫ БАГ ТАМИРЧИД ОЙРЫН ЗАЙН ХОЛИМОГ БУУХИАГ ТУУЛЛАА

"Аравт-2022" олон улсын морин цэргийн уралдааны ойрын зайн холимог буухиа Узбекистан Улсын баг тамирчдаар үргэлжиллээ.

Узбек залуус гараанаас явганаар гарч 3.6 км, 4.1 км замыг морьтой туулах явцдаа маршрутын дагуу байрлах цэгүүдэд өгөгдсөн

даалгаврыг гүйцэтгэж, барианд морьтой орж ирэв.

Тодруулбал, гранат шидэж, саадын зурвас туулж, буудлагын дасгалыг гүйцэтгэж, торон саадыг туулж, мориндоо мордлоо. Үүний дараа тасгийнхан тактикийн талбайн эхлэх заагт тасгийн

захирагчийн дохиогоор нэгийн цуваанд шилжиж, туган саадыг сүлжих даалгаврыг гүйцэтгэж, морины давхилт дунд гранат шидэж, барианд орлоо.

Ингэхдээ даалгавраа гүйцэтгэж чадаагүй нөхцөлд торгуулийн тойрог тойрч байв. Төгсгөлд нь барианд орсон

тамирчдын агт морь, зэвсэг, эд хэрэгслэл бүрэн эсэхийг уралдаан зохион байгуулах хорооныхон шалгасан юм.

Ойрын зайн холимог маргааш Бүгд Найрамдах Зимбабве Улс, Монгол Улсын баг тамирчдаар үргэлжилнэ.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 592,129,086

Эдгэрсэн

Нийт: 563,986,818

Нас барсан

Нийт: 6,444,786

Цахим шууданд

ЦЭРГИЙН ЧУУЛГЫН ҮЙЛС ӨРНҮҮН БАЙНА



Энэ онд 90 жилийн ойтойгоо золгож буй ЦДБЭЧ-ынхан олон ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа билээ. Түүхт ойгоо угтаж Монгол цэрэг Олон Улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойд зориулсан "Үнэ цэн" мюзиклийг шинээр туурвин бүтээж, ард иргэд, Зэвсэгт хүчний анги салбаруудын бие бүрэлдэхүүний хүртээл болгосны зэрэгцээ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан ёсны айлчлалд зориулсан "Бэсрэг наадам", Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн 100 жилийн ой, Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн 90 жилийн ой, Олон Улсын цэргийн

наадмын хүрээнд Увс аймагт зохион байгуулагдсан "Цэргийн авторалли-2022" тэмцээн, "Аравт" морин цэргийн уралдааны нээлт, "Бэсрэг наадам" зэрэг олон улсын арга хэмжээнүүд, ой угтсан хүндэтгэлийн тоглолтыг амжилттай зохион байгуулаад байна. Түүнчлэн чуулгын хамт олон улсын болон олон улсын чанартай уралдаануудын амжилтаа бататгаж Хил хамгаалах байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан "Монгол-Эх орон" найрал дууны болон гоцлол дууны улсын уралдаанд Үндэсний хөгжмийн удирдаач, хөгжмийн зохиолч, СТА хошууч

О.Эрдэнэцог "Баатар Халхын гол" бүтээлээрээ "Тусгай байр"-ын шагнал, Удирдаач СТА ахлах дэслэгч С.Сэргэлэн "Дайчин нөхдийн дурсамж" бүтээлээрээ "Шагналт байр", ОХУ-ын Улаан-Үдэ хотод зохион байгуулагдсан ЗХУ-ын ардын жүжигчин, К.Н.Базарсадаевын нэрэмжит "Эрчүүдийн дуу хоолой" залуу дуурийн дуулаачдын олон улсын VI уралдаанд ахлах ахлагч МУГЖ Б.Батбаатарын удирдлаган дор нөхчин ахлагч Б.Буян, дуучин Г.Алтанхуяг, Г.Чинбаатар нар амжилттай оролцож залуу дуучин Г.Алтанхуяг "Тусгай байр"-ын шагнал, Монгол Улсын Ардын багш, Монгол Улсын Гавьяат жүжигчин, Профессор, нэрт бүжиг дэглээч, судлаач, багш

Г.Долгорсүрэнгийн нэрэмжит "ГОЦЛОЛ БҮЖИГЧДИЙН УЛСЫН АНХДУГААР УРАЛДААН"-нд гоцлол бүжигчин МУСТА ахлах ахлагч Х.Юүлэхорол "Гранпри" шагнал, бүжигчин ахлагч А.Энхжаргал "Тусгай байр"-ын шагналыг хүртэж, Гоцлол бүжигчин ахлагч Б.Бат-Өлзий "Монголын урлагийн ажилтны холбооны нэрэмжит шагнал", БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан 19 дэх удаагийн Олон улсын мэргэжлийн гоцлол бүжигчдын уралдаанд ЦДБЭЧ-ын бүжигчид амжилттай оролцож дэд ахлагч Ч.Чинбат СТА Л.Баттөрийн дэглэлт "Харуулын дайчин" бүжгээр "Дэд байр", бүжигчин Б.Хатансайхан СТА Ш.Дамдинбазарын дэглэлт

"Захчин бий" бүжгээр "Гутгаар байр"-ын шагналыг хүртсэн амжилтыг үзүүлээ. Мөн чуулгын уран бүтээлчдийн амжилтын буухиаг үргэлжлүүлэн ОХУ-д жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаж цэргийн наадмын хүрээнд "Армийн соёл урлаг-2022" уралдаанд оролцохоор ЦДБЭЧ-ын гоцлол дуучин Б.Батбаатараар ахлуулсан уран бүтээлчид хүлгийн жолоо залаад байна. Уран бүтээл, уралдааны наадмын ганзага дүүрэн байгаа тус хамт олон БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу хуваарт сургалтуудыг зохион байгуулж, ажилтан алба хаагчид богино

болон урт хугацааны сургалтад хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлэн ажиллаж байгаа төдийгүй бие бүрэлдэхүүний ажиллах, уран бүтээл туурвих орчныг бүрдүүлэх, үзэгчдэд урлаг, соёлын үйл ажиллагааг таатай орчинд хүргэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гадна фасадны засвар, дээврийн хучилтын ажил, МУУГЗ Ш.Гун-Аажавын үр хүүхдүүдийн санаачлагаар "Манай цэргийн жавхаа" дууны хөшөөний талбайн ногоон байгууламж, цэцэгжүүлэлт, усан оргилуурын тохижилтын ажлуудыг бүрэн хийж гүйцэтгээд байна.

ЭХ ОРНОО БАТЛАН ХАМГААЛЖ БҮЙ ЭР ЦЭРГҮҮДЭЭ ЭРГЭВ



Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

2021 оны хоёр, 2022 оны нэгдүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан залуусаа эргэж үйл ажиллагааг Сүхбаатар дүүргийн ЗДТГ-аас хуваарийн дагуу зохион байгууллаа. Иргэд олон нийт, хүүхэд залууст Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлан таниулах, монгол цэргийн түүхэн уламжлалаа хүндэтгэн түүгээр бахархах, эх оронч үзэл

хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилготой энэхүү арга хэмжээг эр цэргүүд болон тэдний ээж аав, гэр бүл нь талархалтай хүлээж авсан юм. Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Зенитийн артиллерийн дивизионы хугацаат цэргийн алба хаагчдын 50 гаруй хувийг Сүхбаатар дүүргээс татагдсан цэргүүд эзэлж байгаа бөгөөд тэднийг дүүргийн Засаг дарга Х.Болормаа холбогдох мэргэжилтнүүдийн хамт эргэж,

алба хааж буй нөхцөл байдалтай нь танилцсан юм. Хурандаа Г.Отгонбаяр захирагчтай тус ангид алба хааж буй залуус маань албаа нэр төртэй хааж, ангиас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаа, дугуйлангуудад идэвхтэй хамрагдаж өөрсдийгөө нээн хөгжүүлж байна. Тухайлбал, ангийн захирагчийн тушаалаар байгуулсан үлээвэр найрал хөгжмийн салаанд тус дүүргийн олон цэрэг хамрагдаж анхны бие даасан тоглолтоо

зохион байгуулж, ар гэр, ангийн нийт бие бүрэлдэхүүндээ сонирхуулжээ. Мөн тус анги 90 гаруй хугацаат цэргийн алба хаагчаа В, С ангиллын жолооны сургалтад хамруулсны 46 нь Сүхбаатар дүүргийн залуус бөгөөд тэд ийнхүү алба хаах хугацаандаа жолооч мэргэжлийг эзэмшиж байгаа юм. Тус ангиас алба хаагчдын сургалт, өдөр тутмын мэдээг ар гэрт нь хүргэж, санал, хүсэлтийг нь хүлээн авдаг фейсбүүкийн хаалттай группыг хөтөлж байгаа нь талархал

хүлээсэн ажил болжээ. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Н.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг энэ сарын 11-15-ны өдрүүдэд хурандаа Б.Уламжаргал захирагчтай Хилийн цэргийн 0277, хурандаа Д.Ганхуяг захирагчтай Хилийн цэргийн 0311 дүгээр ангиудад алба хааж буй залуусаа эргэсэн юм. Эх орныхоо дархан хилийг хамгаалж буй залуус маань цэргийн эрдэмд шамдан суралцаж, албаа сэтгэл дүүрэн,

нэр төртэй хааж байна. Ийнхүү Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хугацаат цэргийн алба хаагчдынхаа алба хааж буй нөхцөл байдалтай танилцахын зэрэгцээ тэдэнд Засаг даргын гарын бэлэг, дурсгалын зүйлс гардуулсны зэрэгцээ анги, байгууллагад нь эрүүл мэндийг дэмжих, халдвараас хамгаалах хэрэгсэл, компьютер, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн юм.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
 Батлан хамгаалах яам
 Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
 "Соёмбо" сонин
 "Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
 * Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
 * Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисуудын ордон Индекс: 10018
 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
 Утас: 70001029, 3412 (дотуур)